



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 621

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2.1, 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын биет бус хөрөнгө бүртгэлтэй, 55,200,000.00 (тавин таван сая хоёр зуун мянган) төгрөгийн үнэтэй нийтийн эзэмшилд шилжүүлсэн 1200 метр квадрат талбай бүхий газар эзэмших эрх (биет бус хөрөнгө)-ийг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Д.Батчулуун нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ